



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 07 сарын 07 өдөр

Дугаар 1/М8

Дархан

Тамхи худалдан борлуулах энгийн
зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 5.3 дугаар зүйлийн 1 дэх заалт, Тамхины хяналтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.6 дахь заалт, Засгийн газрын 191 дүгээр тогтоолоор батлагдсан “Тамхины үйлдвэрлэл, импорт, худалдаа, үйлчилгээнд хяналт тавих журам”-ын 5.1.4 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2012 оны 52 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Холбогдох хууль тогтоомжийн шаардлага хангасан 14 дүгээр багийн Ардын өргөн чөлөө 2-207 тоот “Аму молл” худалдааны төвд үйл ажиллагаа явуулдаг “Эн Би Эн Хаппи Фэмили” ХХК-ийн “Си юү 303” конвениенс сүлжээ дэлгүүрийн тамхи худалдан борлуулах энгийн зөвшөөрлийг 3 жилээр олгосугай.

2.Холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллахыг энгийн зөвшөөрөл авсан “Эн Би Эн Хаппи Фэмили” ХХК-ийн “Си юү 303” конвениенс сүлжээ дэлгүүрийн захирал (Б.Энхчимэг)-д даалгасугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Худалдаа үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн (С.Шинэзаяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Т.ТУЛГАА



4525010442

D.ajil.Zahiramj-2025